

Article

Artificial intelligence and copyright: new legal challenges in the digital era

Jinjiimaa Nyamdavaa

Department of Private Law, School of Law and Social Sciences, University of Internal Affairs, Ulaanbaatar, Mongolia

*Corresponding author: jinjiimaa.n@uia.gov.mn

 <https://orcid.org/0009-0009-4241-2488>

Received: 13 March 2026. Accepted: 21 May 2026. Published online: 15 June 2026

Abstract

The rapid advancement of digital technologies, particularly the widespread adoption of artificial intelligence (AI)-based systems, has introduced significant challenges to the traditional understanding of intellectual creation and the legal regulation of copyright. AI-driven and generative technologies now enable the creation of various forms of content, including text, images, and music, with varying degrees of human involvement or, in some cases, autonomously. This development raises fundamental legal questions concerning authorship, eligibility for copyright protection, and the scope of applicable legal safeguards.

The purpose of this study is to examine the legal nature of works created with the involvement of artificial intelligence, analyze copyright-related challenges, and comparatively assess the legal framework of Mongolia in light of international developments. The research employs doctrinal legal analysis, comparative legal methods, and document analysis.

The findings reveal that the determination of authorship in AI-assisted works largely depends on the extent of human creative contribution. However, the existing copyright framework remains insufficient to address the emerging legal complexities associated with such works.

This study concludes that it is necessary to clarify the legal status of AI-assisted works and to further refine the scope of copyright protection within the current legal system. The research contributes to ongoing academic and policy discussions on adapting copyright law to the evolving digital environment. This study is of both theoretical and practical significance in that it examines copyright issues related to AI-assisted works within the context of Mongolia's legal framework. Furthermore, the study demonstrates scholarly originality by identifying the necessity for legal reforms aimed at strengthening the protection of intellectual property rights in the digital environment.

Keywords: artificial intelligence, copyright law, intellectual property law, AI-generated works, authorship, digital environment



©2026, Author(s). CC BY-NC 4.0. This license enables reusers to distribute, remix, adapt, and build upon the material in any medium or format for noncommercial purposes only, and only so long as attribution is given to the creator. <https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

Хиймэл оюун ухаан ба зохиогчийн эрх: дижитал эрин үеийн эрх зүйн шинэ сорилт

Нямдаваан **Жинжиймаа**

Хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор, Хувийн эрх зүйн тэнхим Эрх зүй, нийгмийн ухааны сургууль, Дотоод хэргийн их сургууль, Улаанбаатар хот, Монгол Улс

Хураангуй

Дижитал технологийн хурдацтай хөгжил, ялангуяа хиймэл оюун ухаанд суурилсан системүүдийн өргөн хэрэглээ нь оюуны бүтээл бий болгох уламжлалт ойлголт болон зохиогчийн эрхийн эрх зүйн зохицуулалтад шинэ сорилт бий болгож байна. Хиймэл оюун ухааны алгоритм болон генератив технологи ашиглан текст, дүрслэл, хөгжим зэрэг бүтээлийг хүний оролцоотой болон зарим тохиолдолд бие даан бий болгох боломж нэмэгдсэн нь “зохиогч”-ийг тодорхойлох, зохиогчийн эрх олгох боломж, эрхийн хамгаалалтын хүрээг дахин авч үзэх шаардлагыг бий болгож байна.

Энэхүү судалгааны зорилго нь хиймэл оюун ухааны оролцоотойгоор бий болсон бүтээлийн эрх зүйн шинэ чанарыг тодорхойлох, зохиогчийн эрхийн хамгаалалтын асуудлыг судлах, улмаар Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг олон улсын эрх зүйн хөгжлийн чиг хандлагатай харьцуулан дүн шинжилгээ хийхэд оршино. Судалгаанд эрх зүйн шинжилгээний арга, харьцуулсан эрх зүйн арга болон баримт бичгийн судалгааны аргыг ашигласан.

Судалгааны үр дүнгээс үзэхэд хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлд зохиогчийг тодорхойлох асуудал нь хүний бүтээлч оролцооны түвшинтэй шууд холбоотой бөгөөд одоогийн зохиогчийн эрхийн эрх зүйн зохицуулалт нь ийм төрлийн бүтээлийг бүрэн хамарч чадахгүй байна. Иймд хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн статусыг тодорхой болгох, зохиогчийн эрхийн хамгаалалтын хүрээг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна. Энэхүү судалгаа нь хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн зохиогчийн эрхийн асуудлыг Монгол Улсын эрх зүйн орчинтой уялдуулан авч үзсэнээрээ онолын болон практик ач холбогдолтой бөгөөд дижитал орчин дахь оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг боловсронгуй болгох эрх зүйн шинэчлэлийн хэрэгцээг тодорхойлсноороо шинэлэг ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: хиймэл оюун ухаан, зохиогчийн эрх, дижитал эрх зүй, оюуны өмч, хиймэл оюун ухаанаар үүсгэсэн бүтээл

Оршил

Монгол Улсад хиймэл оюун ухаан болон зохиогчийн эрхийн харилцааны талаар хийгдсэн судалгаа харьцангуй хязгаарлагдмал бөгөөд ихэнх судалгаа нь дижитал эрх зүй, мэдээллийн аюулгүй байдал, оюуны өмчийн ерөнхий асуудалд төвлөрсөн байна. Харин хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн зохиогчийг тодорхойлох, сургалтын өгөгдлийн

зохиогчийн эрхийн асуудал, генератив хиймэл оюун ухааны эрх зүйн статус зэрэг асуудлыг дагнан судалсан эрх зүйн судалгаа цөөн байгаа нь энэ чиглэлд цаашид нарийвчилсан судалгаа хийх шаардлагатайг харуулж байна.

Сүүлийн жилүүдэд дижитал технологи, ялангуяа хиймэл оюун ухаанд (AI) суурилсан системүүдийн хөгжил эрчимжиж, оюуны бүтээл бий болгох үйл ажиллагааны хэлбэр, агуулгад мэдэгдэхүйц өөрчлөлт авчирч байна. Хиймэл оюун ухааны алгоритмд суурилсан системүүд текст, дүрслэл, хөгжим, программ хангамж зэрэг олон төрлийн бүтээлийг бий болгох боломжтой болсон нь оюуны өмчийн эрх зүйн уламжлалт ойлголт, ялангуяа зохиогчийн эрхийн институтэд шинэ сорилт, маргаантай асуудлуудыг үүсгэж байна (Abbott, 2020; Ginsburg & Budiardjo, 2019; Surden, 2019).

Зохиогчийн эрхийн уламжлалт онолын дагуу бүтээлийн эрх зүйн хамгаалалт нь хүний оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээлд хамаарах бөгөөд “зохиогч” нь заавал хүн буюу эрх зүйн субъект байх ёстой гэсэн зарчимд тулгуурладаг (Samuelson, 2023). Өөрөөр хэлбэл, зохиогчийн эрх нь хүний бүтээлч хувь нэмэр, оюуны хөдөлмөрийн үр дүнд бий болсон бүтээлийг хамгаалах эрх зүйн механизм юм. Гэвч хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлүүдийн хувьд хүний оролцооны түвшин, алгоритмын бие даасан ажиллагаа, сургалтын өгөгдлийн сангийн нөлөө зэрэг хүчин зүйлс нь зохиогчийг тодорхойлох, эрх эзэмшигчийг тогтоох асуудлыг илүү төвөгтэй болгож байна (WIPO, 2020; Guadamuz, 2020).

Ялангуяа генератив хиймэл оюун ухааны системүүд өргөн хэрэглээнд нэвтэрснээр ийм төрлийн бүтээлийг зохиогчийн эрхийн хамгаалалтад хамруулах эсэх, хэрэв хамруулах бол тухайн эрхийг хэнд олгох асуудал олон улсын хэмжээнд идэвхтэй хэлэлцэгдэж байна. Европын Холбоо, АНУ, Их Британи зэрэг улс орнуудын эрх зүйн бодлого, шүүхийн практикт энэ асуудалд харилцан адилгүй хандлага илэрч байгаа нь хиймэл оюун ухаан болон зохиогчийн эрхийн эрх зүйн зохицуулалт бүрэн төлөвшөөгүй байгааг илтгэнэ (Yanisky-Ravid & Liu, 2018; European Parliament, 2020; Samuelson, 2023).

Монгол Улсад мөн дижитал технологийн хэрэглээ нэмэгдэж, хиймэл оюун ухаанд суурилсан системүүдийг бүтээл туурвих үйл ажиллагаанд ашиглах хандлага эрчимжиж байна. Гэвч одоогийн мөрдөгдөж буй Зохиогчийн эрхийн тухай хууль нь зохиогчийг хүн буюу эрх зүйн субъектээр тодорхойлсон уламжлалт ойлголтод тулгуурласан хэвээр байгаа бөгөөд хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн статусын талаар тусгайлсан зохицуулалт хангалттай тусгагдаагүй байна (Монгол Улс, 2021).

Иймд хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн шинж чанар, зохиогчийн эрхийн хамгаалалтын асуудлыг судлах нь орчин үеийн оюуны өмчийн эрх зүйн судалгаанд онолын болон практик ач холбогдолтой юм. Түүнчлэн Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг

олон улсын эрх зүйн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгаанд хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн зохиогчийн эрхийн асуудлыг эрх зүйн онол болон олон улсын эрх зүйн хөгжлийн чиг хандлагын хүрээнд судлах зорилгоор эрх зүйн судалгааны арга зүйг ашиглав. Судалгааны зорилго нь хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн шинж чанарыг тодорхойлох, зохиогчийн эрхийн хамгаалалтын хүрээнд тулгамдаж буй асуудлыг шинжлэх, улмаар Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг олон улсын туршлагатай харьцуулан үнэлэхэд оршино.

Судалгаанд дараах үндсэн арга зүйг ашигласан болно.

Нэгдүгээрт, эрх зүйн шинжилгээний арга (legal analysis method)-ыг ашиглан зохиогчийн эрхийн үндсэн ойлголт, зарчим, онолын асуудлыг судалж, хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн шинж чанарыг тодорхойлов. Энэ хүрээнд хүний бүтээлч үйл ажиллагаанд суурилсан зохиогчийн эрхийн уламжлалт ойлголт болон хиймэл оюун ухаантай холбоотой орчин үеийн судалгааны үр дүнг шинжилж дүгнэлт хийсэн (Abbott, 2020; Samuelson, 2023; Surden, 2019).

Хоёрдугаарт, харьцуулсан эрх зүйн арга (comparative legal method)-ыг ашиглан хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн зохиогчийн эрхийн асуудлыг олон улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлав. Үүнд Их Британи, АНУ, Европын Холбооны эрх зүйн зохицуулалт, бодлогын баримт бичиг болон холбогдох судалгааны үр дүнг харьцуулан шинжилсэн (European Parliament, 2020; WIPO, 2020; UK Intellectual Property Office, 2022).

Гуравдугаарт, баримт бичгийн судалгааны арга (document analysis method)-ыг ашиглан олон улсын байгууллагын тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл, бодлогын баримт бичиг, мөн Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг судалж, хиймэл оюун ухаан болон зохиогчийн эрхийн харилцаанд тулгамдаж буй эрх зүйн асуудлыг тодорхойлсон (UNESCO, 2021; WIPO, 2023; Монгол Улс, 2021).

Дөрөвдүгээрт, нэгтгэн шинжлэх арга (synthesis method)-ыг ашиглан судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж, хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр санал, дүгнэлтийг боловсруулсан.

Энэхүү судалгаа нь хиймэл оюун ухаан болон зохиогчийн эрхийн харилцааг эрх зүйн онол, олон улсын туршлага, Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоонд авч үзсэн бөгөөд дижитал технологийн хөгжилтэй уялдсан оюуны өмчийн эрхийн хамгаалалтын асуудлыг илүү гүнзгий ойлгоход хувь нэмэр оруулах зорилготой.

Харьцуулсан эрх зүйн судалгаанд АНУ, Европын Холбоо болон Их Британийн эрх зүйн зохицуулалтыг сонгон авч үзсэн бөгөөд эдгээр нь хиймэл оюун ухаан болон зохиогчийн эрхийн асуудлаар харилцан ялгаатай эрх зүйн хандлага баримталж буйгаараа онцлог юм. Харьцуулалтын шалгуурт зохиогчийг тодорхойлох зарчим, хүний бүтээлч оролцооны шалгуур, AI-generated content-ийн хамгаалалтын хүрээ болон сургалтын өгөгдлийн зохицуулалтыг хамруулсан.

Хиймэл оюун ухаан ба зохиогчийн эрхийн онолын асуудал

Зохиогчийн эрх нь оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээлийг хамгаалах зорилготой эрх зүйн институт бөгөөд тухайн бүтээлийг бий болгосон зохиогчид эдийн болон эдийн бус онцгой эрхийг олгодог. Энэхүү эрх зүйн хамгаалалт нь бүтээлийг хуулбарлах, нийтлэх, түгээх, ашиглах зэрэг эдийн эрхээс гадна зохиогчийн нэр хүнд, бүтээлийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах эдийн бус эрхийг хамардаг. Уламжлалт онолын дагуу бүтээл нь хүний оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон тохиолдолд л зохиогчийн эрхийн хамгаалалтад хамрагдана (Samuelson, 2023). Иймд хүний шууд бүтээлч оролцоогүйгээр бий болсон бүтээлийг хамгаалах боломжтой эсэх асуудал орчин үеийн оюуны өмчийн эрх зүйн судалгаанд маргаантай асуудлын нэг болж байна (Guadamuz, 2020; Samuelson, 2023).

Хиймэл оюун ухаанд суурилсан системүүдийн хөгжлийн үр дүнд текст, дүрслэл, хөгжим, программ хангамж зэрэг олон төрлийн бүтээлийг алгоритмын тусламжтайгаар бие даан, эсхүл хүний хязгаарлагдмал оролцоотойгоор бий болгох боломж бүрдсэн. Энэ нь бүтээлч үйл ажиллагаанд технологийн оролцооны цар хүрээг өргөжүүлж, зохиогчийн эрхийн уламжлалт ойлголтыг дахин авч үзэх шаардлагыг бий болгож байна (Abbott, 2020; Surden, 2019). Өөрөөр хэлбэл, “зохиогч” гэх ойлголт нь зөвхөн хүний бүтээлч үйл ажиллагаатай салшгүй холбоотой байх эсэх асуудал онолын түвшинд дахин тодорхойлогдох шаардлагатай болж байна.

Энэхүү асуудлын хүрээнд хэд хэдэн онолын хандлага дэвшүүлэгдэж байна. Нэгдүгээрт, зарим судлаачид хиймэл оюун ухааны системийг бүтээсэн программ хангамжийн хөгжүүлэгчийг тухайн бүтээлийн зохиогч гэж үзэх боломжтой хэмээн тайлбарладаг. Энэ хандлагын дагуу алгоритмын бүтэц, програмчлал, системийн архитектур нь бүтээл үүсэх үндсэн нөхцөлийг бүрдүүлдэг тул хөгжүүлэгчийг “анхдагч бүтээгч” гэж үзэх боломжтой (Abbott, 2020). Гэвч энэхүү байр суурь нь тухайн бүтээлийн эцсийн агуулга, хэлбэрт хөгжүүлэгч шууд нөлөөлөөгүй тохиолдолд зохиогчоор хүлээн зөвшөөрөх нь хэр үндэслэлтэй вэ гэсэн шүүмжлэлд өртдөг.

Хоёрдугаарт, хиймэл оюун ухааныг ашиглан бүтээл бий болгож буй хэрэглэгчийг зохиогч гэж үзэх хандлага өргөн тархаж байна. Энэ үзэл баримтлалын дагуу хиймэл оюун ухаан нь бие даасан зохиогч биш, харин бүтээл туурвих үйл ажиллагаанд ашиглагдаж буй технологийн хэрэгсэл юм. Иймд системд өгөгдөл оруулах, заавар өгөх, бүтээлч чиглэл тодорхойлох замаар эцсийн үр дүнд бодит нөлөө үзүүлж буй хэрэглэгчийг зохиогч гэж үзэх боломжтой (Ginsburg & Budiardjo, 2019). Гэвч хүний оролцоо хязгаарлагдмал, эсхүл зөвхөн техникийн шинжтэй байвал ийм хандлага хангалттай үндэслэлтэй эсэх нь мөн маргаантай хэвээр байна.

Гуравдугаарт, зарим судлаачид хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийг уламжлалт зохиогчийн эрхийн хамгаалалтад хамруулах боломжгүй гэж үздэг. Учир нь зохиогчийн эрхийн хамгаалалтын суурь шалгуур болох хүний бүтээлч оюуны үйл ажиллагааны шаардлага бүрэн хангагдахгүй байж болзошгүй (Samuelson, 2023). Иймээс хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийг зохицуулахад тусгай эрх зүйн дэглэм бий болгох, эсхүл шинэ төрлийн эрхийн институт нэвтрүүлэх шаардлагатай гэсэн санал дэвшүүлэгдэж байна (WIPO, 2020; Guadamuz, 2020).

Дээрх онолын хандлагууд нь хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн статусын талаар нэгдсэн шийдэл бүрдээгүй байгааг харуулж байна. Ийм нөхцөлд зохиогчийг тодорхойлох асуудлыг шийдвэрлэхдээ хүний бүтээлч оролцооны түвшин, алгоритмын үүрэг, технологийн бие даасан байдал, сургалтын өгөгдлийн сангийн нөлөө зэрэг хүчин зүйлсийг цогцоор нь авч үзэх шаардлагатай (Surden, 2019; WIPO, 2023).

Иймээс хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн хувьд зохиогчийн эрхийн уламжлалт онолыг шууд хэрэглэх боломж хязгаарлагдмал бөгөөд эрх зүйн зохицуулалтыг шинэ нөхцөл байдалд нийцүүлэн дахин тодорхойлох шаардлага үүсэж байна.

Олон улсын эрх зүйн зохицуулалтын чиг хандлага

Хиймэл оюун ухаанд суурилсан технологийн эрчимтэй хөгжил нь оюуны бүтээл бий болгох уламжлалт арга барилд үндсэн өөрчлөлт авчирч, зохиогчийн эрхийн эрх зүйн зохицуулалтыг шинэ нөхцөл байдалд нийцүүлэн дахин авч үзэх шаардлагыг бий болгож байна. Ялангуяа генератив хиймэл оюун ухааны системүүд өргөн хэрэглээнд нэвтэрснээр текст, дүрслэл, хөгжим, программ хангамж зэрэг олон төрлийн бүтээлийг автоматжуулсан хэлбэрээр бий болгох боломж нэмэгдэж, зохиогчийн эрхийн хамгаалалтын хүрээ болон зохиогчийг тодорхойлох асуудал олон улсын түвшинд идэвхтэй хэлэлцэгдэх болсон (WIPO, 2020; WIPO, 2023). Үүнтэй холбоотойгоор олон улсын байгууллагууд болон улс орнууд хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн зохиогчийн эрхийн асуудлыг судалж, эрх зүйн бодлого, зохицуулалтын шинэ хандлагыг боловсруулж байна.

Нэгдүгээрт, Их Британийн эрх зүйн зохицуулалт нь хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн асуудлыг харьцангуй эрт зохицуулсан онцлогтой. Тус улсын эрх зүйн хүрээнд “компьютероор бий болсон бүтээл” (computer-generated works) гэсэн ойлголтыг хэрэглэж, ийм төрлийн бүтээлийн зохиогчийг тухайн бүтээлийг бий болгох үйл явцыг зохион байгуулсан этгээд гэж тодорхойлох боломжтой гэж үздэг. Энэхүү хандлага нь хиймэл оюун ухаан болон автоматжуулсан системүүдийн оролцоотой бүтээлд зохиогчийн эрхийн хамгаалалт олгох практик шийдлийг санал болгож буй ч нөгөө талаас хүний бодит бүтээлч хувь нэмрийг хэрхэн үнэлэх вэ гэсэн асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй хэвээр байна (Abbott, 2020; UK Intellectual Property Office, 2022).

Хоёрдугаарт, Европын Холбоо хиймэл оюун ухаантай холбоотой эрх зүйн зохицуулалтыг илүү цогцоор нь боловсруулах бодлого баримталж байна. Европын Парламент болон Европын Комиссын түвшинд хиймэл оюун ухаан, оюуны өмчийн харилцаанд холбогдох олон судалгаа, бодлогын баримт бичиг боловсруулагдсан бөгөөд ялангуяа зохиогчийг тодорхойлох, сургалтын өгөгдлийн ашиглалт, зохиогчийн эрхийн хязгаарлалт зэрэг асуудлыг онцлон авч үзэж байна (European Parliament, 2020; Samuelson, 2023). Энэ хандлага нь хиймэл оюун ухааны ил тод байдал, өгөгдлийн зохицуулалтыг оюуны өмчийн эрхтэй уялдуулан шийдвэрлэхийг зорьж байгаа бөгөөд цаашдын зохицуулалтын хөгжлийн суурийг бүрдүүлж байна.

Гуравдугаарт, АНУ болон зарим улс оронд зохиогчийн эрх нь хүний бүтээлч үйл ажиллагаанд суурилсан байх ёстой гэсэн зарчим давамгайлж, хиймэл оюун ухаан дангаараа бүтээсэн бүтээлийг зохиогчийн эрхээр хамгаалах асуудалд болгоомжтой ханддаг байна. Энэхүү хандлага нь зохиогчийн эрхийн хамгаалалтын суурь шалгуур болох хүний бүтээлч хувь нэмрийг хамгаалах зарчимтай шууд холбоотой бөгөөд хиймэл оюун ухааныг бие даасан зохиогч гэж хүлээн зөвшөөрөхөөс зайлсхийж байгааг харуулж байна (Samuelson, 2023; WIPO, 2020). Гэвч энэ нь практикт хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн статус тодорхойгүй үлдэх нөхцөлийг мөн бий болгож байна.

Дээрх зохицуулалтуудыг харьцуулан үзэхэд улс орнууд хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн асуудалд харилцан адилгүй хандлага баримталж байгаа нь тодорхой байна. Их Британи практик шийдэлд тулгуурласан уян хатан зохицуулалтыг сонгож байгаа бол Европын Холбоо цогц бодлогын түвшинд асуудлыг шийдвэрлэхийг зорьж байна. Харин АНУ уламжлалт зохиогчийн эрхийн зарчмыг хадгалах хандлага давамгайлж байна.

Иймээс олон улсын түвшинд нийтлэг ажиглагдаж буй чиг хандлага нь зохиогчийн эрхийн хамгаалалтын үндсэн шалгуур болох хүний бүтээлч оролцоог хадгалах явдал хэвээр

байгаа боловч хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн статусыг тодорхойлох асуудал бүрэн шийдэгдээгүй, цаашид хөгжих шаардлагатай салбар хэвээр байна.

Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын асуудал

Монгол Улсад зохиогчийн эрхийн харилцааг Зохиогчийн эрхийн тухай хууль-аар зохицуулдаг бөгөөд уг хуулийн дагуу зохиогчийг тухайн бүтээлийг туурвисан хүний оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээлийн бүтээгч гэж тодорхойлсон байдаг (Монгол Улс, 2021). Энэхүү зохицуулалт нь зохиогчийн эрхийн уламжлалт онолд тулгуурлаж, зохиогчийг зайлшгүй хүн буюу эрх зүйн субъект байх ёстой гэсэн зарчмыг баримталж байгааг илэрхийлнэ. Иймээс хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн зохиогчийг тодорхойлох асуудал одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд тусгайлан шийдвэрлэгдээгүй хэвээр байна.

Дижитал технологийн хөгжил, ялангуяа хиймэл оюун ухаанд суурилсан системүүдийн хэрэглээ нэмэгдэж буй нөхцөлд текст, дүрслэл, хөгжим, программ хангамж зэрэг бүтээлийг алгоритмын тусламжтайгаар бий болгох явдал улам түгээмэл болж байна. Гэвч ийм төрлийн бүтээлийн хувьд хүний бүтээлч оролцооны түвшин, хиймэл оюун ухааны системийн бие даасан байдал, сургалтын өгөгдлийн сангийн үүрэг зэрэг хүчин зүйлс нь зохиогчийн эрхийн хамгаалалтыг хэрэгжүүлэхэд эрх зүйн тодорхой бус байдлыг үүсгэж байна (Abbott, 2020; Samuelson, 2023). Энэ нь зохиогчийг тодорхойлох, эрх эзэмшигчийг тогтоох, улмаар эрхийн хамгаалалтыг хэрэгжүүлэхэд практик хүндрэл бий болгож болзошгүй юм.

Тухайлбал, хиймэл оюун ухааныг ашиглан бүтээл бий болгосон тохиолдолд тухайн бүтээлийн зохиогч нь программ хангамжийн хөгжүүлэгч үү, эсхүл системийг ашигласан хэрэглэгч үү, эсвэл ийм төрлийн бүтээлийг зохиогчийн эрхийн хамгаалалтад хамруулах боломжтой эсэх зэрэг асуудал тодорхойгүй хэвээр байна (Samuelson, 2023). Энэхүү тодорхой бус байдал нь цаашид эрх зүйн маргаан үүсэх, шүүхийн практикт зөрүүтэй тайлбар гарах эрсдэлийг нэмэгдүүлэх боломжтой.

Түүнчлэн хиймэл оюун ухааны системийг сургах явцад ашиглагдаж буй өгөгдлийн сан нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан бүтээлүүдийг агуулж болзошгүй бөгөөд энэ нь зохиогчийн эрхийн зөрчил, лицензийн зохицуулалттай холбоотой асуудлыг үүсгэх эрсдэлтэй юм (WIPO, 2020; WIPO, 2023). Ийм нөхцөлд сургалтын өгөгдлийн ашиглалт, бүтээлийн дахин ашиглалт, эрх эзэмшигчийн зөвшөөрөл зэрэг асуудлыг эрх зүйн хүрээнд илүү нарийвчлан зохицуулах шаардлага үүсэж байна.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд Монгол Улсын одоогийн зохиогчийн эрхийн эрх зүйн зохицуулалт нь хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн онцлогийг бүрэн тусгаж чадахгүй, тодорхой хэмжээнд хоцрогдолтой шинжтэй байна гэж дүгнэж болохоор байна. Иймээс олон улсын эрх зүйн хөгжлийн чиг хандлага, ялангуяа Европын Холбоо, АНУ, Их Британи зэрэг

улс орнуудын туршлагыг харгалзан үзэж, хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн статусыг тодорхойлох, зохиогчийн эрхийн хамгаалалтын хүрээг нарийвчлах, шаардлагатай тохиолдолд тусгай зохицуулалт бий болгох нь зүйтэй.

Энэ нь нэг талаас дижитал эдийн засгийн хөгжлийг дэмжих, нөгөө талаас оюуны бүтээлийн эрхийн хамгаалалтыг баталгаажуулах эрх зүйн суурь нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Хүснэгт 1. Хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн зохиогчийн эрхийн талаарх олон улсын хандлагын харьцуулалт

Улс / бүс нутаг	Зохицуулалтын үндсэн хандлага	Зохиогчийг тодорхойлох зарчим
Их Британи	Computer-generated work хүлээн зөвшөөрдөг.	Бүтээл үүсгэх үйл явцыг зохион байгуулсан этгээд
АНУ	Хүний бүтээлч оролцоог гол шалгуур болгодог.	Зөвхөн хүний оролцоотой бүтээл хамгаалагдана.
Европын Холбоо	AI ба IP асуудлыг цогц бодлогоор зохицуулах хандлагатай.	Хүний бүтээлч хувь нэмрийг чухалчилдаг.
Монгол Улс	Тусгай зохицуулалт хангалтгүй.	Зохиогчийг хүний оюуны бүтээлч үйл ажиллагаатай холбон үздэг.

Дээрх харьцуулалтаас үзэхэд улс орнууд хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн зохиогчийн эрхийн асуудалд харилцан адилгүй хандлага баримталж байгаа нь ажиглагдаж байна. Ялангуяа хүний бүтээлч оролцоог үндсэн шалгуур болгон үзэх хандлага нийтлэг байгаа боловч зохицуулалтын арга хэлбэрийн хувьд ялгаатай байна. Монгол Улсын хувьд энэ чиглэлээр тусгай зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байсаар байна.

Хэлэлцүүлэг

Хиймэл оюун ухааны технологийн хөгжил нь оюуны бүтээл бий болгох үйл явц дахь хүний оролцооны хэлбэр, цар хүрээг мэдэгдэхүйц өөрчилж, зохиогчийн эрхийн уламжлалт эрх зүйн ойлголтыг дахин авч үзэх шаардлагыг бий болгож байна. Энэхүү судалгааны үр дүнгээс үзэхэд хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн зохиогчийг тодорхойлох асуудал олон улсын түвшинд нэгдсэн шийдэлд хүрээгүй бөгөөд улс орнууд харилцан адилгүй эрх зүйн хандлага баримталж байна (WIPO, 2020; Samuelson, 2023).

Тухайлбал, Их Британийн эрх зүйн зохицуулалтад компьютероор бий болсон бүтээлийн зохиогчийг тухайн бүтээлийг бий болгох үйл явцыг зохион байгуулсан этгээд гэж тодорхойлох хандлага ажиглагддаг бөгөөд энэ нь хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлд зохиогчийн эрхийн хамгаалалт олгох практик боломжийг бүрдүүлж байна (Abbott, 2020; UK Intellectual Property Office, 2022). Гэвч энэхүү зохицуулалт нь хүний бодит бүтээлч хувь нэмрийг хэрхэн үнэлэх, алгоритмын үүргийг ямар хэмжээнд тооцох зэрэг асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй хэвээр байна.

Нөгөө талаас, зарим улс оронд зохиогчийн эрх нь хүний бүтээлч үйл ажиллагаанд суурилсан байх ёстой гэсэн зарчим давамгайлж, хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийг хамгаалах асуудалд илүү болгоомжтой хандлага ажиглагдаж байна. Энэхүү хандлага нь зохиогчийн эрхийн хамгаалалтын үндсэн шалгуур болох хүний бүтээлч хувь нэмрийг хадгалах зорилготой боловч практикт хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн статус тодорхойгүй хэвээр үлдэх нөхцөлийг мөн бий болгож байна (Samuelson, 2023; Guadamuz, 2020).

Европын Холбооны хувьд хиймэл оюун ухаан болон оюуны өмчийн эрхийн харилцааг илүү цогцоор нь авч үзэж, технологийн хөгжил болон зохиогчийн эрхийн хамгаалалтын хоорондын зохистой тэнцвэрийг хангах бодлогын арга хэмжээг боловсруулах чиглэлээр идэвхтэй ажиллаж байна (European Parliament, 2020; WIPO, 2023). Энэ нь хиймэл оюун ухааны ил тод байдал, өгөгдлийн ашиглалт, зохиогчийн эрхийн хамгаалалтын хүрээг уялдуулан зохицуулах шаардлагатайг харуулж байна.

АНУ-ын “Thaler v. Perlmutter” хэргийн хүрээнд зөвхөн хиймэл оюун ухаанаар бүрэн үүсгэсэн бүтээлд зохиогчийн эрх олгохоос татгалзсан нь хүний бүтээлч оролцоог зохиогчийн эрхийн үндсэн шалгуур гэж үзэж буй орчин үеийн хандлагыг тодорхой харуулсан. Энэхүү шүүхийн практик нь хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн статусыг тодорхойлоход олон улсын хэмжээнд чухал жишиг болж байна.

Монгол Улсын хувьд зохиогчийн эрхийн тухай хууль нь хүний оюуны бүтээлч үйл ажиллагаанд суурилсан уламжлалт ойлголтыг баримталж байгаа бөгөөд хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн статусыг тодорхой тусгаагүй байна (Монгол Улс, 2021). Ийм нөхцөлд хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлүүд нэмэгдэхийн хэрээр зохиогчийг тодорхойлох, эрх эзэмшигчийг тогтоох, зохиогчийн эрхийн хамгаалалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн тодорхой бус байдал үүсэх эрсдэл өндөр байна.

Иймээс судалгааны үр дүнд тулгуурлан дүгнэхэд, Монгол Улсын хувьд хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохдоо олон улсын эрх зүйн хөгжлийн чиг хандлагыг харгалзан үзэхийн зэрэгцээ хүний бүтээлч оролцоог тодорхойлох шалгуурыг нарийвчлах, хиймэл оюун ухааны үүрэг, оролцоог эрх зүйн хүрээнд тодорхойлох шаардлагатай байна. Энэ нь нэг талаас дижитал технологид суурилсан инновацыг дэмжих, нөгөө талаас зохиогчийн эрхийн хамгаалалтыг баталгаажуулах эрх зүйн тэнцвэрийг хангах үндэс болох юм.

Эрх зүйн шинэчлэлийн чиглэл

Хиймэл оюун ухаанд суурилсан технологийн хурдацтай хөгжил нь бүтээл туурвих үйл ажиллагааны хэлбэр, арга зүйд үндсэн өөрчлөлт авчирч, зохиогчийн эрхийн уламжлалт эрх

зүйн зохицуулалтыг шинэ нөхцөл байдалд нийцүүлэн шинэчлэх шаардлагыг бий болгож байна. Ялангуяа хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн статус, зохиогчийн эрхийн хамгаалалтын хүрээ, эрх эзэмшигчийг тодорхойлох асуудал нь орчин үеийн оюуны өмчийн эрх зүйн бодлогын төв асуудлын нэг болж байна. Иймээс хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь технологийн хөгжил болон оюуны өмчийн эрхийн хамгаалалтын хоорондын зохистой тэнцвэрийг хангахад чухал ач холбогдолтой (Abbott, 2020; WIPO, 2020).

Нэгдүгээрт, хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн статусыг тодорхойлох шаардлагатай. Одоогийн зохицуулалтад зохиогчийн эрхийн хамгаалалт нь хүний оюуны бүтээлч үйл ажиллагаанд суурилдаг тул хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн шинж чанар тодорхой бус хэвээр байна. Иймээс ийм төрлийн бүтээлийг зохиогчийн эрхийн хамгаалалтад хамруулах эсэх, хэрэв хамруулах бол ямар нөхцөл, шалгуурын үндсэн дээр хамгаалах асуудлыг эрх зүйн түвшинд тодорхойлох нь зүйтэй (Samuelson, 2023; Guadamuz, 2020).

Хоёрдугаарт, зохиогчийг тодорхойлох шалгуурыг илүү нарийвчлан тогтоох шаардлагатай. Хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн хувьд хүний бүтээлч оролцооны түвшин, алгоритмын үүрэг, өгөгдлийн боловсруулалтын нөлөө зэрэг хүчин зүйлс нь зохиогчийг тодорхойлох үндэслэл болж болох тул “хүний бүтээлч оролцооны шалгуур” (human creative contribution test)-ыг эрх зүйн зохицуулалтад тусгах боломжийг судлах нь зүйтэй (Ginsburg & Budiardjo, 2019). Ийнхүү хүний оролцоог тодорхой шалгуурын үндсэн дээр үнэлэх нь зохиогчийг тогтоох эрх зүйн тодорхой байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Гуравдугаарт, дижитал орчин дахь оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Хиймэл оюун ухааны системийг хөгжүүлэх, ашиглах явцад их хэмжээний өгөгдөл, оюуны бүтээл ашиглагддаг тул зохиогчийн эрхийн хамгаалалт болон технологийн хөгжлийн хоорондын зохистой тэнцвэрийг хангах эрх зүйн зохицуулалт онцгой ач холбогдолтой (European Parliament, 2020; WIPO, 2023). Үүнтэй холбоотойгоор хиймэл оюун ухааны системийн ил тод байдал, сургалтын өгөгдлийн ашиглалт, зохиогчийн эрхийн хязгаарлалт, зөвшөөрлийн зохицуулалтыг цогцоор нь авч үзэх шаардлагатай.

Дээрхээс дүгнэхэд, хиймэл оюун ухаан болон зохиогчийн эрхийн харилцааг зохицуулах эрх зүйн шинэчлэл нь зөвхөн хууль тогтоомжийн өөрчлөлтөөр хязгаарлагдахгүй, харин бодлогын түвшинд цогц хандлага шаардсан асуудал юм. Ийм шинэчлэл нь технологийн хөгжлийг дэмжихийн зэрэгцээ оюуны бүтээлийн эрхийн хамгаалалтыг баталгаажуулах,

улмаар дижитал эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах суурь нөхцөл болох ач холбогдолтой.

Дүгнэлт

Хиймэл оюун ухаанд суурилсан технологийн хурдацтай хөгжил нь оюуны бүтээл бий болгох уламжлалт ойлголт болон зохиогчийн эрхийн эрх зүйн зохицуулалтад үндсэн өөрчлөлт авчирч, шинэ сорилтуудыг бий болгож байна. Ялангуяа хиймэл оюун ухааны оролцоотойгоор төрөл бүрийн бүтээлийг бий болгох боломж нэмэгдсэн нь “зохиогч”-ийг тодорхойлох, зохиогчийн эрх олгох шалгуур, эрхийн хамгаалалтын хүрээг дахин авч үзэх шаардлагыг бий болгож байна. Иймээс хиймэл оюун ухаан болон зохиогчийн эрхийн харилцаа нь орчин үеийн оюуны өмчийн эрх зүйн судалгаанд онолын болон практик ач холбогдол бүхий тулгамдсан асуудал болж байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд олон улсын түвшинд хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн зохицуулалт нэгдсэн байдлаар бүрэн төлөвшөөгүй бөгөөд улс орнууд харилцан адилгүй хандлага баримталж байна. Нэг талаас, зарим улс оронд компьютероор бий болсон бүтээлийн зохиогчийг тухайн үйл явцыг зохион байгуулсан этгээдтэй холбон тодорхойлох хандлага ажиглагддаг бол нөгөө талаас, зохиогчийн эрх нь хүний бүтээлч үйл ажиллагаанд суурилсан байх ёстой гэсэн уламжлалт зарчим давамгайлж байна. Үүний зэрэгцээ олон улсын байгууллагууд хиймэл оюун ухаан болон оюуны өмчийн харилцааг цогцоор нь авч үзэх бодлогын арга хэмжээг идэвхтэй хэлэлцэж байгаа нь уг асуудал эрх зүйн хөгжлийн чухал чиглэл болж байгааг илтгэнэ.

Монгол Улсын хувьд зохиогчийн эрхийн эрх зүйн зохицуулалт нь хүний оюуны бүтээлч үйл ажиллагаанд суурилсан уламжлалт ойлголтод тулгуурлаж байгаа бөгөөд хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн статусыг тодорхой тусгасан зохицуулалт хангалтгүй байна. Энэ нь дижитал орчинд бий болж буй шинэ төрлийн бүтээлийн эрхийн хамгаалалт, зохиогчийг тодорхойлох, эрх эзэмшигчийн хүрээг тогтоох асуудалд эрх зүйн тодорхой бус байдал үүсгэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Иймээс цаашид Монгол Улсын зохиогчийн эрхийн эрх зүйн зохицуулалтыг шинэ технологийн хөгжилтэй уялдуулан боловсронгуй болгох шаардлагатай. Үүнд: хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрх зүйн статусыг тодорхойлох, хүний бүтээлч оролцоонд суурилсан зохиогчийг тодорхойлох шалгуурыг нарийвчлах, хиймэл оюун ухааны сургалтын өгөгдөл болон бүтээлийн ашиглалттай холбоотой зохиогчийн эрхийн хамгаалалтыг тодорхой зохицуулах зэрэг чиглэл багтана.

Эцэст нь дүгнэж хэлэхэд, хиймэл оюун ухаан болон зохиогчийн эрхийн харилцааг зохицуулах эрх зүйн шинэчлэл нь технологийн хөгжлийг дэмжихийн зэрэгцээ оюуны

бүтээлийн эрхийн хамгаалалтыг баталгаажуулах, улмаар дижитал эдийн засаг, инновацийн тогтвортой хөгжлийг хангах суурь нөхцөл болох юм. Иймээс олон улсын туршлага, технологийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн цогц эрх зүйн зохицуулалтыг боловсруулах нь Монгол Улсын эрх зүйн бодлогын чухал зорилт хэвээр байна.

Цаашид Монгол Улсад зохиогчийн эрхийн тухай хуульд хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн талаарх тусгай зохицуулалт нэмж, “хүний бүтээлч оролцооны шалгуур”-ыг хуульчлан тодорхойлох, AI системийн сургалтын өгөгдлийн ашиглалтад холбогдох зөвшөөрөл болон лицензийн механизмыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна. Мөн хиймэл оюун ухааны оролцоотой бүтээлийн эрхийн маргааныг шийдвэрлэх шүүхийн практик, мэргэжлийн тайлбар боловсруулах нь эрх зүйн тодорхой байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Ашигласан материалын жагсаалт

- Abbott, R. (2020). *The reasonable robot: Artificial intelligence and the law*. Cambridge University Press. <https://doi.org/10.1017/9781108631761>
- European Parliament. (2020). *Intellectual property rights for the development of artificial intelligence technologies*. European Union.
- Gervais, D. (2020). Artificial intelligence and copyright: Ownership without authorship? *Columbia Journal of Law & the Arts*, 43(2), 1–28.
- Ginsburg, J. C., & Budiardjo, L. A. (2019). Authors and machines. *Berkeley Technology Law Journal*, 34(2), 343–388.
- Guadamuz, A. (2017). Artificial intelligence and copyright. *World Intellectual Property Review*, 1(1), 14–17.
- Guadamuz, A. (2020). Do androids dream of electric copyright? Comparative analysis of originality in AI-generated works. *Intellectual Property Quarterly*, 2, 169–186. <https://doi.org/10.1093/oso/9780198870944.003.0008>
- Hilty, R. M., Hoffmann, J., & Scheuerer, S. (2019). Intellectual property justification for artificial intelligence. *International Review of Intellectual Property and Competition Law*, 50(9), 1072–1090. <https://doi.org/10.1007/s40319-019-00859-3>
- Kaplan, J., & Haenlein, M. (2019). Siri, Siri in my hand: Who’s the fairest in the land? *Business Horizons*, 62(1), 15–25. <https://doi.org/10.1016/j.bushor.2018.08.004>
- Lemley, M. A., & Casey, B. (2021). Fair learning. *Texas Law Review*, 99(4), 743–785.
- McCutcheon, J. (2021). AI-generated works and copyright law. *Journal of Intellectual Property Law & Practice*, 16(2), 109–117. <https://doi.org/10.1093/jiplp/jpaa190>

- Samuelson, P. (2023). Generative AI meets copyright. *Science*, 381(6654), 158–161.
<https://doi.org/10.1126/science.adi0656>
- Schwab, K. (2017). *The fourth industrial revolution*. Crown Business.
- Searle, J. (1980). Minds, brains, and programs. *Behavioral and Brain Sciences*, 3(3), 417–457.
<https://doi.org/10.1017/S0140525X00005756>
- Strowel, A. (2020). Copyright protection for AI-generated works: A European perspective. *Journal of Intellectual Property Law & Practice*, 15(11), 870–879.
<https://doi.org/10.1093/jiplp/jpaa116>
- Surden, H. (2019). Artificial intelligence and law: An overview. *Georgia State University Law Review*, 35(4), 1305–1337.
- UK Intellectual Property Office. (2022). *Artificial intelligence and intellectual property: Copyright and patents consultation*. UKIPO.
- UNESCO. (2021). *Recommendation on the ethics of artificial intelligence*. UNESCO Publishing.
- WIPO. (2019). *WIPO technology trends 2019: Artificial intelligence*. World Intellectual Property Organization.
- WIPO. (2020). *Revised issues paper on intellectual property policy and artificial intelligence*. World Intellectual Property Organization.
- WIPO. (2023). *Generative artificial intelligence and copyright*. World Intellectual Property Organization.
- Yanisky-Ravid, S., & Liu, X. (2018). When artificial intelligence systems produce inventions: An alternative model for patent law. *Cardozo Law Review*, 39(6), 2215–2260.
<https://doi.org/10.2139/ssrn.2931828>
- Yu, P. K. (2020). Artificial intelligence and intellectual property. *Texas A&M Law Review*, 7(4), 1005–1047.
- Монгол Улс. (2021). *Зохиогчийн эрхийн тухай хууль* (шинэчилсэн найруулга). Төрийн мэдээлэл.
- Монгол Улсын Их Хурал. (2020). *Алсын хараа-2050: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого*. Улаанбаатар.